

***Дорноговь аймгийн Төрийн Аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн
ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн
аудитын тайлан***

**“Өмнөх онуудад орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн
хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний үр дүн”**



**Хөрөнгө оруулалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх тодорхой
ажил зохион байгуулах шаардлагатай байна.**

2018 он

АГУУЛГА

| | |
|--|--|
| <p>Тайланг бэлтгэсэн:</p> <p>Дорноговь аймгийн Төрийн аудитын газар</p> <p>Дарга, Тэргүүлэх аудитор Ч.Ариунаа</p> <p>Аудитын менежер Ц.Лүндэгмаа</p> <p>Аудитор П.Энхбаяр Аудитор Б.Тунгалагтуяа</p> <p>2018 оны 10 дугаар сар</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7052-2734, 7052-3020 дугаарын утас,7052-2734 дугаарын факсаар харилцана уу</p> <p>ХАЯГ: Орон нутгийн өмчийн 3-р байр</p> | <p>Товчилсон үгийн тайлбар -----3</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.-----4-5</p> <p>БҮЛЭГ 1. Захиалагч, гүйцэтгэгч, ажил хүлээн авах комиссын хариуцлагагүй байдлаас төсөл арга хэмжээ хугацаандаа хэрэгжээгүй, ашиглалт хангалтгүй байна.</p> <p>1.1 Гэрээний хэрэгжилтэд тавих хяналт, гүйцэтгэгчийн ажлын хариуцлага сул байгаагаас төсөл арга хэмжээ тухайн хугацаандаа хэрэгжээгүй, дутуу орхигдсон байна.Орон нутгийн хөгжлийн сан-----6-10</p> <p>1.2. Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ чанарын шаардлагад нийцээгүй, ашиглалтгүй байгаа нь хөгжлийн сан, хөрөнгө оруулалтын бодлого, зорилтын биелэлтийг хангахгүй байдалд оруулж байна.-----10-14</p> <p>БҮЛЭГ 2. Хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт хангалтгүй байна.</p> <p>2.1 Хөрөнгийн ашиглалт, чанарыг сайжруулах ажил зохион байгуулаагүй байна. -----14-17</p> <p>2.2 Хөрөнгийн ашиглалт хамгаалалт болон тэдгээрийн бүртгэл тайлагналд тавих хяналт хангалтгүй байна.-----17-19</p> <p>Дүгнэлт-----20</p> <p>Зөвлөмж-----21</p> <p>Холбогдох байгууллагын санал-----22</p> <p>Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар-----23</p> <p>Тайлан баталгаажуулсан тушаал-----24</p> |
|--|--|

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|--------------|---|
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| МУЕА | Монгол улсын ерөнхий аудитор |
| ТАХ | Төсөл арга хэмжээ |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| НААҮОНӨ ХХК | Нийтийн аж ахуй үйлчилгээ орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ЦДАШ | Цахилгаан дамжуулах агаарын шугам |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ТАХ | Төсөл арга хэмжээ |
| ЗГ | Засгийн газар |
| ААНБ | Аж ахуй нэгж байгууллага |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ГХБХБГ | Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар |
| ТБОНӨХБАҮХАТ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай |
| СЗДТГ | Сумын Засаг даргын тамгын газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| | |

АУДИТЫН ТУХАЙ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/106 дугаар тушаалаар батлагдсан 2018 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны төлөвлөгөө, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт: 2013-2017 онуудад орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээ түүний үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэлээ. Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дараах дэд зорилтын хүрээнд асуудлыг авч үзсэн. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалт үр дүнтэй хэрэгжсэн эсэх.
- Хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих хяналт үр дүнтэй эсэх.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт: Дараах хууль эрхийн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур, эх сурвалж болгон ашиглав.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаал
- Иргэний хууль
- Барилгын тухай хууль
- Засгийн газрын 2017 оны 69 дүгээр тогтоолоор баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Бусад холбогдох эрх зүйн актууд.

Хамарсан хүрээ: Аудитаар орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2013-2017 онд санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүн, ашиглалтыг Айраг, Алтанширээ, Дэлгэрэх, Иххэт, Өргөн, Эрдэнэ, Замын-Үүд, Хатанбулаг, Хөвсгөл, Сайншанд, Даланжаргалан, Улаанбадрах сумдын ЗДТГ-ыг хамруулан, хөрөнгийн ашиглалттай танилцаж ажил гүйцэтгэх гэрээ, хүлээн авсан комиссын акт, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад баримт материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй: Аудитыг гүйцэтгэхдээ Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглан, шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа авах, худалдан авалт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын судалгаа, үр дүнгийн мэдээллийг боловсрууллаа.

Аудитын хугацаа: Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2018 оны 06 дугаар сарын 11-нд эхлүүлж, аудитын талбарын ажлыг 2018 оны 06 дугаар сарын 11-ээс 9 дүгээр сарын 14-ны өдрүүдэд гүйцэтгэж, 2018 оны 9 дүгээр сарын 17-ноос эхлэн тайлангийн төсөл боловсруулан, удирдлагын санал авч, шалгагдагч байгууллагад 2018 оны 10 дугаар сарын 01-нд хүргүүлэн санал авч, 10 дугаар сарын 10-нд эцэслэн боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэв.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн: Аудитыг Дорноговь аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ч.Ариунаа удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежерийг түр орлон гүйцэтгэгч Ц.Лүндэгмаа хэрэгжүүлж, аудитор П.Энхбаяр, аудитор Тунгалагтуяа нар гүйцэтгэв.

Үндсэн мэдээлэл: Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2013-2017 онд 12.4 тэрбум төгрөгийн, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 26.3 тэрбум төгрөгийн төсөл арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.

| Хөрөнгө оруулалт | 2013 он | 2014 он | 2015 он | 2016 он | 2017 он |
|----------------------------|---------------|----------------|---------------|---------------|---------------|
| Аймгийн ОНХСан | 3415.5 | 3425.2 | 1445.7 | 2630.1 | 671.5 |
| Сумын ОНХСан | 4677.0 | 3637.5 | 1789.5 | 2863.2 | 1782.9 |
| ОНТөсвийн хөрөнгө оруулалт | 1724.0 | 2997.2 | 2545.9 | 2755.1 | 6995.1 |
| ДҮН | 9816.5 | 10059.9 | 5781.1 | 8248.4 | 9449.5 |

Бүлэг 1.

Захиалагч, гүйцэтгэгч, ажил хүлээн авах комиссын хариуцлагагүй байдлаас төсөл арга хэмжээ хугацаандаа хэрэгжээгүй, ашиглалт хангалтгүй байна.

1.1. Гэрээний хэрэгжилтэд тавих хяналт, гүйцэтгэгчийн ажлын хариуцлага сул байгаагаас төсөл арга хэмжээ тухайн хугацаандаа хэрэгжээгүй, дутуу орхигдсон байна.

1.1.1. Гүйцэтгэгч гэрээний үүргээ хуулийн дагуу биелүүлээгүйгээс ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэсэн 244.5 сая төгрөгийн ТАХ хугацаандаа хэрэгжээгүй байна.

2013-2017 онд орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжүүлсэн 26.0 тэрбум төгрөгийн ТАХ-ээс 1.8 тэрбум гаруй төгрөгийн 39 төсөл арга хэмжээ буюу 10-30 хувь нь дараах шалтгааны улмаас хугацаандаа хэрэгжээгүй, чанар байдал, ашиглалтын шаардлагыг хангахгүй байна.

- *Гүйцэтгэгч гэрээний үүргээ хугацаанд нь хэрэгжүүлээгүй, ТАХ-г дутуу орхисон, аж ахуйн нэгж байгууллагуудад хариуцлага тооцоогүй*
- *Хяналт хангалтгүйгээс төсөл, арга хэмжээний хэрэгжилт удааширсан.*
- *Барилга байгууламж ашиглалтад оруулах комисс дүрмийн заалтыг зөрчиж ТАХ-г хүлээн авсан.*
- *ТАХ чанарын шаардлага хангахгүй болсон.*
- *Барилгын баталгаат чанарын хугацаа болон ашиглалтын явцад гарсан зөрчлийг арилгуулаагүй.*
- *Нягтлан бодох бүртгэлд тусгаагүй.*

Аудитад хамрагдсан сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2013-2017 хэрэгжүүлсэн ТАХ-ний ашиглалтын үзүүлэлтийг хүснэгтээр харуулав.

| Байршил | Чанар | 2013 | | 2014 | | 2015 | | 2016 | | 2017 | |
|---------------|-------------|------|--------|------|---------|------|--------|------|--------|------|-------|
| | | ТАХ | Дүн | ТАХ | Дүн | ТАХ | Дүн | ТАХ | Дүн | ТАХ | Дүн |
| Айраг | Хэрэгжсэн | 10 | 352.3 | 14 | 371.1 | 6 | 76.9 | 10 | 233.7 | 4 | 103.1 |
| | Ашиглалтгүй | 1 | 68.1 | 5 | 82.9 | 1 | 19.4 | 0 | - | 1 | 51.4 |
| Алтанширээ | Хэрэгжсэн | 5 | 181.3 | 5 | 340.1 | 3 | 90.2 | 7 | 192.0 | 7 | 77.5 |
| | Ашиглалтгүй | 0 | - | 2 | 80.2 | 0 | - | 0 | - | 0 | - |
| Даланжаргалан | Хэрэгжсэн | 5 | 286.6 | 5 | 203.7 | 2 | 147.2 | 1 | 104.8 | 1 | 10.0 |
| | Ашиглалтгүй | 1 | 143.7 | 3 | 174.8 | 0 | - | 0 | - | 0 | - |
| Иххэт | Хэрэгжсэн | 6 | 145.1 | 8 | 338.5 | 3 | 107.6 | 5 | 75.4 | 4 | 60.4 |
| | Ашиглалтгүй | 0 | - | 0 | - | 0 | - | 0 | - | 0 | - |
| Дэлгэрэх | Хэрэгжсэн | 10 | 256.5 | 20 | 304.0 | 3 | 96.9 | 9 | 138.8 | 5 | 64.2 |
| | Ашиглалтгүй | 0 | - | 3 | 98.0 | 1 | 56.9 | 1 | 9.5 | 1 | 17.5 |
| Хатанбулаг | Хэрэгжсэн | 11 | 112.2 | 20 | 466.1 | 6 | 167.8 | 10 | 230.8 | 7 | 150.4 |
| | Ашиглалтгүй | 0 | - | 4 | 76.2 | 0 | - | 0 | - | 0 | - |
| Хөвсгөл | Хэрэгжсэн | 9 | 377.0 | 9 | 392.3 | 5 | 117.0 | 13 | 173.1 | 9 | 98.6 |
| | Ашиглалтгүй | 0 | - | 0 | - | 0 | - | 2 | 80.0 | 0 | - |
| Улаанбадрах | Хэрэгжсэн | 8 | 158.7 | 8 | 434.9 | 7 | 116.5 | 4 | 115.0 | 6 | 164.2 |
| | Ашиглалтгүй | 0 | - | 0 | - | 0 | - | 1 | 20.2 | 0 | - |
| Өргөн | Хэрэгжсэн | 4 | 261.3 | 10 | 357.9 | 3 | 97.9 | 7 | 228.1 | | |
| | Ашиглалтгүй | 0 | - | 0 | - | 0 | - | 0 | - | 0 | - |
| Эрдэнэ | Хэрэгжсэн | 15 | 251.1 | 5 | 343.7 | 2 | 193.4 | 6 | 107.9 | 5 | 73.0 |
| | Ашиглалтгүй | 0 | - | 0 | - | 0 | - | 0 | - | 0 | - |
| Замын-Үүд | Хэрэгжсэн | 11 | 780.5 | 8 | 783.5 | 3 | 190.6 | 4 | 371.1 | 2 | 34.2 |
| | Ашиглалтгүй | 2 | 247.5 | 1 | 99.5 | 1 | 55.9 | 3 | 222.0 | 0 | - |
| Сайншанд | Хэрэгжсэн | 17 | 535.6 | 15 | 1,178.0 | 7 | 224.5 | 5 | 248.0 | 2 | 99.5 |
| | Ашиглалтгүй | 1 | 109.0 | 1 | 10.0 | 1 | 24.8 | 2 | 61.6 | 0 | - |
| Дүн | Хэрэгжсэн | 111 | 3698.2 | 127 | 5513.8 | 50 | 1626.5 | 81 | 2218.7 | 52 | 935.1 |
| | Ашиглалтгүй | 5 | 568.3 | 19 | 621.6 | 4 | 157.0 | 9 | 393.3 | 2 | 68.9 |

Хүснэгтээс харахад 12 сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 1.8 тэрбум гаруй төгрөгийн 39 төсөл арга хэмжээ чанарын шаардлагыг бүрэн хангаагүй, огт ашиглагдаагүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж, орон нутгийн иргэдийн тогтвор суурьшилтай амьдрал, иргэдийн аж байдалд эерэг таатай нөлөөлөл бий болгох, ээлтэй орчин бүрдүүлэхэд чиглэгдэнэ гэсэн ОНХС-ийн үндсэн зорилгыг хангахгүй байна.

Гэрээний үүргээ Иргэний хуулийн дагуу хэрэгжүүлээгүй¹, барилга байгууламжийн ажлыг дутуу орхисон дараах аж ахуйн нэгжид хариуцлага хүлээлгэх ажлыг зохион байгуулаагүйгээс 244.5 сая төгрөгийн төсөл арга хэмжээ дуусаагүй байна.

¹. Иргэний хуулийн 350 дугаар зүйл. Ажил гүйцэтгэгчийн үүрэг

350.1.Ажил гүйцэтгэгч нь дараахь үүрэг хүлээнэ:

350.1.1.гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх;

350.1.6.захиалагчийн өмчлөлд ямар нэгэн доголдолгүй үр дүнтэй шилжүүлэх;

350.1.7.ажлын үр дүнгийн доголдлыг арилгахад шаардагдах зардлыг /ажлын хөлс, материалын зардал, замын хураамж болон тээврийн хөлс г.м/ хариуцах;

350.1.8.өөрийн материалаар ажил гүйцэтгэх бол зохих чанарын материалаар гүйцэтгэх.

Дуусаагүй зарим ТАХ-ны жагсаалтыг хүснэгтээр харуулав.

| Байршил | ТАХ-ний нэр | Төсөвт өртөг | Гүйцэтгэгч | Гэрээ | | Илэрсэн зөрчил |
|------------|---|--------------|-----------------------|--------------|--------|--------------------------------|
| | | | | Эхлэх | Дуусах | |
| Айраг | ЕБС-ийн биеийн тамирын талбайн гүйлтийн зам байгуулах | 51.4 | Дуулгат мөрөн ХХК | 2017 | 2017 | Дуусаагүй, гэрээ сунгагдаагүй. |
| Замын-Үүд | Замын-Үүд сумын Хилийн замын харуулын /З-ын хаалт/ тохижилт | 99.5 | Бадрах мандал шим ХХК | 2014 | 2014 | Дутуу хийгдсэн. |
| Зүүнбаян | Халуун усны барилгын өргөтгөл | 10 | Иргэн Б.Баярсайхан | 2014 | 2014 | Дуусаагүй дутуу орхисон |
| Зүүнбаян | 78-н айлын орон сууцны 2 дахь шатны сантехник угсралт | 30.6 | Цэцэйхэн марал ХХК | 2016 | 2016 | Дуусаагүй дутуу орхисон |
| Алтанширээ | Гэрэлтүүлэг нэмэх | 30.0 | Илч шанд ХХК | 2014 | 2014 | Ажлаа эхлүүлээд орхисон |
| Хөвсгөл | Хогийн цэг цэгцлэх, шуух | 23.0 | Хүрэл унага ХХК | 2016 | 2016 | Дуусаагүй дутуу орхисон |
| Дүн | | | | 244.5 | | |

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2013-2017 онд нийт 12.0 тэрбум төгрөгийн 146 төсөл арга хэмжээ хэрэгжсэн байна.

| № | Төсөл арга хэмжээний нэр | Төсөл арга хэмжээний тоо | Мөнгөн дүн /сая.төг/ |
|-----------------|------------------------------|--------------------------|----------------------|
| 1 | <i>Шинэ хөрөнгө оруулалт</i> | 25 | 4026.5 |
| 2 | <i>Их засвар</i> | 64 | 5281.5 |
| 3 | <i>Тоног төхөөрөмж</i> | 29 | 1401.6 |
| 4 | <i>ТЭЗҮ, зураг төсөл</i> | 28 | 1341.7 |
| Нийт дүн | | 146 | 12,051.3 |

Замын-Үүд сумын төсвийн хөрөнгө оруулалтаар Сүлд багт 12.0 сая төгрөгийн төсөв бүхий элсний волейбол, сагсны талбай байгуулах ажлыг Мөнгөн сүлд иргэдийн бүлэг 2015 онд гүйцэтгэхээр гэрээ байгуулсан бөгөөд Төрийн аудитын газраас тухайн үед ажил дуусгаагүй байсанд албан шаардлага өгсөн байна. Албан шаардлагын дагуу Сумын ЗДТГ-аас гүйцэтгэгч байгууллагыг сум дундын Шүүхэд шилжүүлсэн ба Шүүгчийн 2018 оны 6 дугаар сарын 137/ШШ/2018/00143 дугаар захирамжаар гүйцэтгэгч байгууллагаар ажлыг гүйцэтгүүлэхээр болсон байна.

Захиалагчаас гэрээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй, гүйцэтгэгч байгууллагуудын ажлын хариуцлага сул, гэрээний үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, ажлыг дутуу орхисон байхад холбогдох албан тушаалтан, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хариуцлага хүлээлгэх, төсвийн хөрөнгийг үргүйдүүлэх асуудлаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулаагүй байна.

1.1.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс журмын дагуу ажиллаагүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2013-2017 онд хэрэгжүүлсэн дараах 217.7 сая төгрөгийн төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэл чанаргүй, ажил дутуу, гүйцэтгээгүй байхад холбогдох журмын² заалтыг зөрчин

²ЗГ-ын 2017 оны 69 дүгээр тушаалаар батлагдсан дүрмийн 4.1-д Барилга байгууламж ашиглалтад оруулах комисс (цаашид “комисс” гэх) дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

байнгын ашиглалтад хүлээн авсан нь хөрөнгө ашиглалтгүй байх нөхцөлийг бүрдүүлжээ. Комиссын хүлээн авсан зарим ТАХ-ний жагсаалтыг хүснэгтээр харуулав.

| Байршил | ТАХ-ний нэр | Төсөвт өртөг | Гүйцэтгэгч | Гэрээ | | УКА огноо | Илэрсэн зөрчил |
|---------------|-----------------------------------|--------------|--------------------|--------------|--------|-----------|-------------------------------|
| | | | | Эхлэх | дуусах | | |
| Даланжаргалан | Хүүхэд залуучуудын парк байгуулах | 143.7 | Сүмэр Гүн ХХК | 2013 | 2013 | 14.06.27 | Дуусаагүй байхад хүлээн авсан |
| Зүүнбаян | Тоглоомын талбай байгуулах | 24.8 | Говь тарвас ХХК | 2015 | 2015 | 15.08.18 | Дутуу хийгдсэн. |
| Хатанбулаг | Соёлын төвийн барилгын | 30 | Цэцэйхэн марал ХХК | 2014 | 2014 | 14.06.16 | Дутуу хийгдсэн. |
| Хатанбулаг | Нийтийн бие засах газар байгуулах | 19.2 | Иргэн Ганчулуу | 2014 | 2014 | 14.09.04 | Чанаргүй хийгдсэн |
| Дүн | | | | 217.7 | | | |

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Иххэт суманд СНТ ХХК 2016 онд 734.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Спорт цогцолборын барилга угсралтын ажлыг гүйцэтгэж барилга байгууламжийг 2016 оны 8 дугаар сард 20/2016 дугаартай комиссын актаар ашиглалтад хүлээлгэн өгчээ. Аймагийн Төрийн аудитын газраас 2017 онд барилгын ажлыг чанаргүй материалаар гүйцэтгэсэнээс ашиглалтын явцад гарсан эвдрэл гэмтлийг дахин засварлуулахаар албан шаардлагыг хүргүүлсэн. Гүйцэтгэгч байгууллагаас дутуу ажлуудыг хийж гүйцэтгэсэн тухай тайлан ирүүлсэн хэдий ч одоогийн байдлаар барилгын зүүн хойд хэсгийн гадна бетон хаяавчинд суулт өгсөн, барилгын баруун, зүүн, ар талын хананд ихээхэн хэмжээний цууралт үүссэн, гадна талын дулаалгын хөөс ховхорч унасан, дээврээс ус гоожиж заал болон коридорын зарим гэрэлтүүлэг ажиллахгүй болсон байна.



Иххэт сум Спорт цогцолборын барилга

ЗГ-ын 2017 оны 69 дүгээр тушаалаар батлагдсан дүрмийн 4.4-д Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаж, комиссын гишүүд хариуцсан асуудал тус бүрээр санал гаргана. Комиссын нийт гишүүдийн саналыг үндэслэн комиссын дүгнэлтийг гаргах бөгөөд уг дүгнэлтийг комиссын нийт гишүүд гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

ЗГ-ын 2017 оны 69 дүгээр тушаалаар батлагдсан дүрмийн 4.7-д Комиссын гишүүд үүрэг, даалгавар бүрээр гүйцэтгэсэн ажлын биелэлтэд урьдчилан үнэлэлт, дүгнэлт өгсөн байх бөгөөд комиссын хуралдаанаар үүрэг даалгаврын биелэлтийг нэгтгэн хэлэлцэж дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

ЗГ-ын 2012 оны 151 дүгээр тушаалаар батлагдсан дүрмийн 4 дэх заалт,

Усан спорт, сургалтын төвийн барилгын ажлыг Баян могод ХХК гүйцэтгэж 2018 оны 7 дугаар сард хүлээлгэн өгчээ. Ашиглалтад орсон сар гаруйн хугацаанд дараах зөрчлүүд гарсан байна. Үүнд:

- *Бороо орсны улмаас барилгын зүүн урд тал цөмөрч их хэмжээний ус дотогшоо нэвтэрч узель усанд автсан.*
- *Ус дотогшоо их хэмжээгээр орсноор үйлчлүүлэгчдийн сандлын мод ховхорсон, мөн цахилгааны шит шатаж дахин ашиглах боломжгүй болсон.*
- *Барилгын дээврээс ус гоожиж таазанд ус тогтсон.*



Усан спорт, сургалтын төвийн барилга

Тус барилгуудыг ашиглахтай холбоотой барилгын гадаад дотоод тохижилт, засвар үйлчилгээ, ашиглалтын зардал болон ажиллах хүчний цалин хөлс зэрэг зардлууд шийдвэрлэгдээгүй байна.

Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6³, 14.7⁴, 14.3⁵, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 4.19⁶-д заасны дагуу чанар, стандартын шаардлага хангаагүй баригдсан Иххэт сумын Спорт цогцолборын барилга, Усан спортын төвийн барилгад гарсан зөрчлүүдийг холбогдох гүйцэтгэгч компаниар арилгуулах 2 албан шаардлага өгөв.

Ажил дуусаагүй, чанаргүй хийгдсэн байхад ашиглалтад хүлээн авах үйл ажиллагаа зохион байгуулсан албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

1.2. Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ чанарын шаардлагад нийцээгүй, ашиглалтгүй байгаа нь хөгжлийн сан, хөрөнгө оруулалтын бодлого, зорилтын биелэлтийг хангахгүй байдалд оруулж байна.

³ Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна.

⁴ Энэ хуулийн 14.6-д заасан хугацаанд гарсан зөрчлийг захиалагч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч, материал ханган нийлүүлэгч, эзэмшигчийн аль буруутай этгээд арилгаж, хохирлыг барагдуулна.

⁵ Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна.

⁶ Барилгын чанарын баталгаат хугацаа “Барилгын тухай хууль”-ийн 14 дүгээр зүйлийг баримтлах бөгөөд баталгаат хугацаанд байгалийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс бусад шалтгаанаас үүдэн барилга байгууламжид эвдрэл, гэмтэл гарвал гүйцэтгэгч байгууллага захиалагчийн шаардлагаар үнэ төлбөргүй засварлана.

1.2.1 ОНХС болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 533.8 сая төгрөгийн төсөл арга хэмжээ ашиглалтгүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 533.8 сая төгрөгийн төсөл арга хэмжээ ашиглалтын зардал шийдэгдээгүй, хулгайд алдсан, эвдэрсэн, үе шатны ажлын дараах үеийн төсөв шийдэгдээгүй, галд шатсан, хэрэглэгч байхгүй зэрэг шалтгаанаар ашиглалтгүй байна. Тухайлбал:

Айраг сум 2-р хорооны гэр байрны гудамжны гэрэлтүүлгийн үргэлжлэлд гэрэлтүүлэг тавих 17.8 сая төгрөгийн ажил 2013 он: СЗДТГ-ын цахилгааны төсөв хүрэлцдэггүй шалтгаанаар ашиглалтгүй байна.

Айраг сум Гэр байр болон Точикийн байрны замын гэрэлтүүлэг тавих 17.8 сая төгрөгийн ажил. 2014 он: СЗДТГ-ын цахилгааны төсөв хүрэлцдэггүйгээс 2015 оноос эхлэн өнөөг хүртэл ашиглалтгүй байна.

Айраг сум Салаа замын хажуу овоон дээр нарны эх үүсвэртэй гэрэлтүүлэг тавих 19.3 сая төгрөгийн ажил 2014 он: Гэрэлтүүлгийн эд ангиуд хулгайд алдагдсан, үлдсэн зай хураагуурын шингэн асарч ашиглах боломжгүй болсон.

Айраг сумын Халамжийн төвийн эд хөрөнгө бэлтгэх 10.0 сая төгрөгийн ажил 2014 он: зориулалтын дагуу ашиглагдаагүй.

Замын-Үүд сумын Сүлд багийн 11-р хэсгийн тохижилтын 95.5 сая төгрөгийн ажил 2016 он: Тавигдсан хайрган замыг дараа онд нь хавтан хучилт хийхээр төлөвлөсөн боловч санхүүжилт шийдэгдээгүй тул замыг эвдрэлээс сэргийлж хаасан.

Замын-Үүд сумын 3-р багт Цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл барих, гэрэлтүүлэг суурилуулах 89.8 сая төгрөгийн ажил. 2016 он: Ашиглах хэрэглэгч суурьшаагүй, зарим эд ангиуд хулгайд алдагдсан, ашиглагч байгууллага зарим хөрөнгийг урьдчилан сэргийлж салгасан.

Даланжаргалан сумын Гэрэлт цамхаг байгуулах 105.7 сая төгрөгийн ажил. 2014 он: Гэрэлтүүлгийн эд ангиуд хулгайд алдагдсан, баганын шавардлага нурсан.

Дэлгэрэх сумын Ундны ус цэвэршүүлэх, шүүх тоног төхөөрөмжтэй болох, худгийн байр барих, гадна талбайн тохижилтын 20.0 сая төгрөгийн ажил. 2014 он: Суурилуулсан ус цэвэршүүлэх төхөөрөмжийн холболт доголдолтой тул салгасан.

Дэлгэрэх сумын Гудамжны нэгдсэн гэрэлтүүлэгтэй болох 55.1 сая төгрөгийн ажил. 2014: Нийт 35 гэрэл суурилуулснаас 12 гэрэл бүтэн боловч асахгүй, 23 гэрэл хагарч шатсан, ихэнх шон хугарсан, аккумуляторуудыг хулгайд алдсан тул хүчин чадлаар ашиглах боломжгүй.

Зүүнбаян 78-н айлын орон сууц 2 дахь шатны сантехник угсралтын ажил 30.7 сая төгрөгийн ажил 2016 он: Гэрээний дагуу ажил гүйцэтгэж дуусаагүй орхигдсон.

Алтанширээ Цэнгэг ус эрүүл орчин байгуулах ундны усны худаг шинээр гаргах цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах 52.9 сая төгрөгийн ажил ХХК 2014 он: 2016 онд галлагааны улмаас шатсан ашиглах боломжгүй болсон.

Хатанбулаг сумын Нийтийн бие засах газар байгуулах 19.2 сая төгрөгийн ажил 2014 он: Тус ажлын хүрээнд хийсэн ЗДТГ-ын дотор шинээр байгуулсан 00 нь ашиглалтгүй.

Айраг сум Салаа замын хажуу овоон дээр нарны эх үүсвэртэй гэрэлтүүлэг

Дэлгэрэх сум: Гудамжны нэгдсэн гэрэлтүүлэг



ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдэх ТАХ-ний нийт 100 гаруй ажил гүйцэтгэх гэрээг ангилж үзэхэд, зарим ААНБ жилд 3 ба түүнээс дээш 4-9 хүртэл ажлыг нэгэн зэрэг гүйцэтгэж байгаа нь ТАХ-ний хэрэгжилт удаашрах, төлөвлөсөн хугацаанд үр дүнгээ өгөхгүй байхаас гадна хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж байна. Үүнд:

- 2013 онд БЭМЭС ХХК 4 суманд 9 ТАХ, Мөрөөдлийн говь 3 суманд 5 ТАХ,
- 2014 онд Цэцэйхэн марал ХХК 2 суманд 3 ажил,
- 2015 онд Говь тарвас ХХК 3 суманд 3 ажил,
- 2016 онд Гэрлээр тэтгэгч ХХК 3 суманд 3 ТАХ, БДЗ ХХК 2 суманд 4 ТАХ

Хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн ажлууд нь чанаргүй, дуусаагүй байгаа зарим ААНБ-ыг дурдвал:

- Цэцэйхэн марал ХХК-ний 2014 онд гүйцэтгэсэн 3 ажлаас Зүүнбаян багийн 78-н айлын орон сууцыг дэд бүтцэд холбох ажил дуусаагүй,
- Говь тарвас ХХК 2014 онд 3 ажил гүйцэтгэсэн бөгөөд Хатанбулаг сумын соёлын төвийн засварын ажил дутуу, Дэлгэрэх сумын худаг, ус цэвэршүүлэх тоног төхөөрөмж угсралтын ажил шаардлага хангахгүй, Зүүнбаян багт суурилуулсан тоглоомын талбай байгуулах ажил дутуу,
- Гэрлээр тэтгэгч ХХК 2016 онд 3 ажил гүйцэтгэснээс Дэлгэрэх сумын төвийг камержуулах ажил чанарын шаардлага хангахгүй ашиглалтгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн 135.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл арга хэмжээ ашиглалтгүй байна.

Таримал жимсийг норм аргачлалын дагуу суулгаж тариалаагүй, хүлэмжийг техникийн тодорхойлолтод заасны дагуу хийгээгүй, газар тариалангийн усалгааны системийг оновчтой байршилд шийдвэрлээгүйгээс хөрөнгө оруулалтаар хийгдсэн зарим ажлуудын үр ашгийг хүртээгүй, өнөөг хүртэл ашиглалтгүй байна. Тухайлбал:

- Замын-Үүд сумын 3 дугаар багт 15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дөрвөн улирлын зориулалтаар хүлэмж барих ажлыг Урт богино жалга ХХК 2015 онд гүйцэтгэн ашиглалтад хүлээлгэн өгчээ. Хүлэмжийн зарим цонх цуурч хагарсан, дээврийн хэсгийн гялгар уут салхинд урагдсан, хүлэмж дотор

тариалсан ногоо, ургамал байхгүй, хөрөнгийг өмнөх онуудад ашиглаж байсан нь тодорхой бус байна.

- Тус сумын 3 дугаар багийн 2 га газарт чацаргана тариалах ажлыг Ган суварга ТББ 2015 онд 9.0 сая төгрөгөөр гүйцэтгэж 6 дугаар сард ашиглалтад хүлээлгэн өгсөн байна. Чацаргана жимс ургаагүй, зарим суулгац элсэнд дарагдсан, арчилгаа услалт огт хийгдээгүй, талбай элс хогонд дарагдсан байна.
- Газар тариалангийн усалгааны систем байгуулах ажлыг Замын-Үүд суманд Чандмань бадрал ХХК 2016 онд 16.6 сая төгрөгөөр гүйцэтгэжээ. Ажил гүйцэтгэх гэрээнд 2016 оны 05 сард хүлээлгэн өгнө гэсэн боловч уг төсөл арга хэмжээг комиссын актаар хүлээн авсан эсэх нь тодорхой бус, хүлээн авах комисс томилсон Засаг даргын захирамж болон ажил хүлээлгэн өгсөн баримт материал байхгүй байна. Уг хөрөнгийг ашиглахгүй байгаагаас шалтгаалан ус шахдаг худаг доторх зарим тоног төхөөрөмж алдагдсан, худгийн дээвэр, хаалга эвдэрсэн байна.

Хөрөнгө оруулалтаар хийгдсэн гудамж, зам талбай, барилга байгууламжийн хаяг, автозамын тэмдэг, тэмдэглэгээ болон театрын үзэгчдийн зарим сандал ашиглагдаагүй, байгууллагын агуулахад хадгалагдаж байна.

- Замын-Үүд суманд 2016 онд багуудын хаяг шинэчлэн хийх 33.9 сая төгрөгийн ажлаар жижиг хаяг 2221, том хаяг 140, байшингийн хаяг 357, гудамжны хаяг 40 ширхгийг тус тус хийсэн байна. Шинээр олгосон газарт айл буугаагүй, хашаагүй айлуудад хаяг байршуулах боломжгүйгээс хийгдсэн хаягуудын зарим хэсэг ашиглагдаагүй агуулахад хадгалагдаж байна.
- Автозамын тэмдэг, тэмдэглэгээ шинэчлэх ажлаар 2015 онд Сайншанд суманд 17.2 сая төгрөгийн 138 ширхэг тэмдэг хийгдсэнээс 42 тэмдгийг суурилуулаагүй Сайншанд Хот Тохижилтын газрын агуулахад хадгалагдаж байна.
- Аймгийн Саран Хөхөө театр 2016 онд 400 ширхэг үзэгчдийн сандал худалдан авснаас 337 ширхгийг суурилуулж, үлдэгдэл 15.8 сая төгрөгийн 123 ширхэг сандал байгууллагын агуулахад хадгалагдаж байна.

Хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагыг урьдчилан судалж, үр өгөөжийг тооцож төлөвлөөгүйгээс үр ашиггүй зардал гарсан байна.

- Сайншанд суманд байрлах Соёмбо цогцолборын нэг өрөөг 5D кинотеатр болгон тохижуулахаар 2016 онд 9.9 сая төгрөгөөр өрөөний засвар хийгджээ. Кинотеатрын үйл ажиллагаа явуулах зориулалтын тоног төхөөрөмж байхгүй тул өрөөг зориулалтаар нь ашиглаж үйл ажиллагаа явуулаагүй байна.
- Сумдын багийн дарга, хэсгийн төлөөлөгчдийн албан хэрэгцээнд зориулж 2014-2017 онуудад сумдад олгосон мотоциклоос Хатанбулаг суманд 14.6 сая төгрөгийн 10 ширхэг, Иххэт суманд 1.7 сая төгрөгийн 1 ширхэг, Дэлгэрэх

суманд 1.7 сая төгрөгийн 1 ширхэг буюу нийт 18.0 сая төгрөгийн мотоцикл ашиглах боломжгүй байна. Тухайлбал:

Сумдын багийн Засаг дарга нар зарим мотоциклын сэлбэг хэрэгслийн олдоц муу, таарах сэлбэг байдаггүй, мөн сэлбэг хэрэгсэл худалдан авах төсөв байдаггүй гэсэн шалтгаанаар хөрөнгө ашиглалтгүй байгаа тухай тайлбар өгсөн болно.

Шат шатны ИТХ болон Засаг дарга нар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд⁷ заасан бүрэн эрхийн хүрээнд зохион байгуулагдах орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдлыг хянан шалгах ажлыг хангалтгүй гүйцэтгэжээ.

1.2.2. Хэрэгжүүлсэн тухайн ТАХ-ний чанарын баталгаат хугацаанд төсвөөс хөрөнгө зарцуулаагүй байна.

Өмнөх онуудад хийгдсэн чанаргүй ажлуудыг сэргээн засварлахаар /чанарын баталгаат хугацаанд/ төсвөөс дахин зардал гаргасан эсэхийг судлахад хөрөнгө оруулалт болон урсгал засварын зардлын төсвөөс хөрөнгө зарцуулаагүй байна.

Харин зарим сумдын урьд онуудад хийгдсэн гудамж талбайг хаягжуулах, замын тэмдэг тэмдэглэгээг нэмэгдүүлэх ажлуудыг Хаягжуулалтын тухай хууль, журам шинэчлэгдсэнтэй холбогдуулан 2018 онд дахин төлөвлөн хийхээр болсон байна.

Бүлэг 2.

Хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт хангалтгүй байна.

2.1 Хөрөнгийн ашиглалт, чанарыг сайжруулах ажил зохион байгуулаагүй байна.

2.1.1 Ашиглагч байгууллага хөрөнгийн ашиглалт, хөрөнгө оруулалтын үр дүнг сайжруулах талаар ажил зохион байгуулаагүйгээс хөрөнгө ашиглалтгүй байсаар байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн дараах ажлуудын чанар байдал, ашиглалтыг сайжруулах тодорхой ажил зохион байгуулаагүйгээс хийгдсэн хөрөнгө оруулалт төлөвлөсөн үр дүнд хүрэхгүй байна. Тухайлбал:

Айраг сумын ЗДТГ:

⁷ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйл. Орон нутгийн өмчийн талаархи иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

77.2-д Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараахь бүрэн эрхтэй

77.2.1-д орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах

78.2-д Засаг дарга иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний дотор орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах;

- 2013-2014 онд тавьсан нийт 35.6 сая төгрөгийн гэрэлтүүлэг: Ашиглалтын зардлыг холбогдох газруудад хандан шийдвэрлүүлээгүй,
- 2014 онд суурилагдсан Салаа замын хажуу овоон дээр нарны эх үүсвэртэй 19.3 сая төгрөгийн гэрэлтүүлэг: Хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцуулаагүй
- 2014 онд бэлтгэсэн Халамжийн төвийн тохижилтын 10.0 сая төгрөгийн эд хөрөнгө: Хөрөнгийг зориулалтаар ашиглах арга хэмжээ аваагүй

Замын Үүд сумын ЗДТГ, Замын-Үүд НААҮОНӨ ХХК:

- Сүлд багийн 11-р хэсгийн тохижилтын 95.5 сая төгрөгийн ажил 2016 он: Сайжруулсан хайрган замын хавтан хучилтыг төлөвлөн шийдвэрлүүлээгүй Залуучуудын өргөн чөлөөний 4-н замын гэрлэн дохио хийх 71.6 сая төгрөгийн ажил. 2016 он: Цагдаагийн постын барилгын бүрэн бүтэн байдлыг хангуулах, гэрлэн дохионд тохиргоо хийх зэргээр хөрөнгийн ашиглалтыг сайжруулаагүй

Даланжаргалан сумын ЗДТГ:

- Гэрэлт цамхаг байгуулах 105.7 сая төгрөгийн ажил 2014 он: Хулгайд алдсан хөрөнгийн асуудлаар холбогдох байгууллагат хандаагүй

Дэлгэрэх сумын ЗДТГ:

- Ундны ус цэвэршүүлэх, шүүх тоног төхөөрөмжтэй болох, худгийн байр барих, гадна талбайн тохижилтын 20.0 сая төгрөгийн ажил 2014 он: Ус цэвэршүүлэх төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулаагүй
- Гудамжны нэгдсэн гэрэлтүүлэгтэй болох 55.1 сая төгрөгийн ажил. 2014: Нийт 35 гэрэл суурилуулснаас 12 гэрэл бүтэн боловч асахгүй, 23 гэрэл хагарч шатсан, шон хугарсан, аккумуляторуудыг хулгайд алдсан зөрчлүүдийг холбогдох байгууллагад хандаагүй, бүрэн бүтэн болгож ашиглаагүй

Сайншанд сумын ЗДТГ:

- Зүүнбаян 78-н айлын орон сууц 2 дахь шатны сантехник угсралтын ажил 30.7 сая төгрөгийн ажил 2016 он: Гэрээний дагуу ажил гүйцэтгэж дуусаагүй. Гэрээний хэрэгжилтийг хангуулаагүй
- Зүүнбаян багийн Халуун усны барилгын өргөтгөлийн 10.0 сая төгрөгийн ажил 2014 он: Дутуу ажлыг дуусгуулаагүй

Алтанширээ сумын ЗДТГ:

- Цэнгэг ус эрүүл орчин байгуулах ундны усны худаг шинээр гаргах цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах 52.9 сая төгрөгийн ажил 2014 он: Шатаж ашиглах боломжгүй болсон хөрөнгийг бүтэн болгох, ашиглалтыг сайжруулаагүй

Улаанбадрах сумын ЗДТГ:

- Нийтийн ахуй үйлчилгээний барилгын засварын 20.2 сая төгрөгийн ажил. 2016 он: Шатсан хөрөнгийг бүрэн бүтэн болгох асуудлыг шийдээгүй,

Хатанбулаг сумын ЗДТГ:

- Хатанбулаг сумын Нийтийн бие засах газар байгуулах 19.2 сая төгрөгийн ажил 2014 он: Тус ажлын хүрээнд хийсэн ЗДТГ-ын дотор шинээр байгуулсан бие засах газрын ашиглалтыг сайжруулах ажил зохион байгуулаагүй.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл арга хэмжээг хэрэгжүүлсний дараа ямар байгууллагад эзэмшүүлэх, үйл ажиллагааны зардлыг ямар эх үүсвэрээс санхүүжүүлэх, ашиглалтыг хэрхэн сайжруулах талаар урьдчилан судлалгүйгээр дараах төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

- Сайншанд сумын 4 дүгээр багт 24.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Усан сангийн худгийн барилгыг 2017 оны 8 дугаар сард улсын комисс ашиглалтад хүлээлгэн өгсөн боловч өнөөг хүртэл хөрөнгийн ашиглагч байгууллага тодорхой бус, хөрөнгө ашиглалтгүй байна.
- Замын сангийн хөрөнгөөр 2017 санхүүжигдсэн Цагдаагийн газрын Замын цагдаагийн постын барилга нь шалнаасаа халдаг бөгөөд гэрэл цахилгааны зардлын төсөв шийдэгдээгүйгээс зарим өрөө тасалгааг ашиглаагүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-аар хийгдсэн ажлуудын чанар байдал, ашиглалтыг сайжруулах талаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн⁸ дагуу ажил зохион байгуулж хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлэх шаардлагатай байна.

Хөрөнгийн ашиглалтын зардлыг шийдвэрлүүлэх, бүрэн бүтэн байдлыг хангуулах, ашиглалтыг сайжруулах 535.8 сая төгрөгийн 8 ш албан шаардлага бичив.

2.1.2 Чанарын баталгаат хугацаанд гарсан эвдрэл гэмтлийг гүйцэтгэгчээр засварлуулаагүй байна.

Барилгын тухай хуулийн 14.6-д “Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна” гэж заажээ.

Сангийн сайдын 2016 оны 415 тушаалын 4.19-д “Барилгын чанарын баталгаат хугацаанд...эвдрэл, гэмтэл гарвал гүйцэтгэгч байгууллага захиалагчийн шаардлагаар үнэ төлбөргүй засварлана” гэж заасан. ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэсэн 109.3 сая төгрөгийн ажлуудад гарсан зөрчлийг гүйцэтгэгчийн чанарын баталгаат хугацаанд барагдуулаагүй байна. Тухайлбал:

Замын-Үүд сумын Залуучуудын өргөн чөлөөний 4-н замын гэрлэн дохио хийх 71.6 сая төгрөгийн ажил. Гүйцэтгэгч нь Сүлжээт зам ХХК 2013 он: Цагдаагийн постын барилга цонх хагарсан, шавардлага хуурсан, гэрлэн дохионд тохиргоо хийгдэх шаардлага бий болсон. Гүйцэтгэгч чанарын баталгаат хугацаанд гарсан зөрчлийг барагдуулаагүй. Ашиглагч байгууллага зөрчил арилгуулах талаар санал гаргаагүй байна.

Дэлгэрэх сумын төвийг камержуулах 17.5 сая төгрөгийн ажил. Гүйцэтгэгч нь Гэрлээр тэтгэгч ХХК 2017 он: Суурилагдсан нийт 5 камераас 1 нь огт ажиллахгүй, 4 ашиглалтын шаардлага хангахгүй бичлэг хийдэггүй, шөнө ажиллахгүй, программ нь алдаа заадаг. Гүйцэтгэгч чанарын баталгаат хугацаанд гарсан зөрчлийг барагдуулаагүй бөгөөд Ашиглагч байгууллага зөрчил арилгуулах талаар санал гараагүй.

Улаанбадрах Нийтийн ахуй үйлчилгээний барилгын засварын 20.2 сая төгрөгийн ажил. Гүйцэтгэгч нь БЭМЭС ХХК 2016 он: Ашиглалтгүй байсан барилгыг иргэнд түрээслүүлсэн боловч 2017 онд дээвэр тааз, хучилт бүрэн шатсаны улмаас ашиглах боломжгүй болсон. Гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн гарсан доголдлыг чанарын баталгаат хугацаанд бүрэн барагдуулаагүй.

⁸ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 80 дугаар зүйл. Орон нутгийн өмчийг эзэмших, захиран зарцуулахтай холбогдсон харилцааг энэ хуулийн тавдугаар бүлэгт заасны дагуу зохицуулна.

Улаанбадрах сум: Нийтийн ахуй үйлчилгээний барилгын засварын ажил



Замын-Үүд сумын 4-н замын гэрлэн дохио



Гүйцэтгэгчийн чанарын баталгаат хугацаанд гарсан зөрчлийг арилгуулахаар 37.7 сая төгрөгийн 2 албан шаардлага бичив.

Замын сангийн хөрөнгөөр Сайншанд Хамрын хийдийн чиглэлийн автозамд төлбөр хураах цэг байгуулах 97.5 сая төгрөгийн ажлыг Оргил таур ХХК 2014 онд гүйцэтгэжээ. Уг ажил нь тухайн үед зураг төсвийн дагуу хийгдээгүй, том машин явах зам байхгүй, зам талбайн тохижилтын ажил дутуу хийгдсэнд аймгийн Төрийн аудитын газраас 2015 оны 5 дугаар сард албан шаардлага өгсөн байна.

Тасалбар хураах цэгийн барилгатай холбоотой гарсан зөрчлийг аймгийн Цагдаагийн газраас шалгасан боловч асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу мэдээллийг холбогдох байгууллагад одоог хүртэл хүргүүлээгүй байна.

2.2 Хөрөнгийн ашиглалт хамгаалалт болон тэдгээрийн бүртгэл тайлагналд тавих хяналт хангалтгүй байна.

2.2.1 Хулгайд алдсан хөрөнгийг холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлээгүй байна.

Ашиглалтын хугацаанд хулгайд алдсан дараах хөрөнгийн талаар хуулийн байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй байна.

- Айраг сумын Салаа замын хажуу овоон дээр нарны эх үүсвэртэй гэрэлтүүлэг тавих ажил 2014 он: *Гэрэлтүүлгийн зай хураагуур, дагалдах эд анги*
- Даланжаргалан Гэрэлт цамхаг байгуулах ажил 2014 он: *Гэрлийн зай хураагуур, дагалдах хэрэгслүүд*
- Хатанбулаг сумын төвд Хиймэл хүрхрээ барих ажил 2014 он: *Байгууламжийн насос*

Ашиглагч байгууллагууд дээрх хулгайд алдсан эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангуулж, ашиглалтыг сайжруулах ажил зохион байгуулах нь зүйтэй.

2.2.2 Хөрөнгө оруулалт, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж ашиглалтад оруулсан 1069.5 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд бүртгэлд тусгаагүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр өмнөх онуудад хэрэгжүүлсэн 493.0 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

- Замын-Үүд Сүлд багийн 11-р хэсгийн тохижилтын 94.5 сая төгрөгийн ажил 2016 он:
- Замын-Үүд 1-р багийн 9-р хэсэгт сайжруулсан 56.9 сая төгрөгийн ажил 2015 он:
- Замын-Үүд 1-р багийн 9.10 хэсгийн тохижилтын 144.5 сая төгрөгийн ажил 2013 он:
- Замын-Үүд Залуучуудын өргөн чөлөөний 4-н замын гэрлэн дохио хийх 71.6 сая төгрөгийн ажил. 2013 он:
- Замын-Үүд Нийтийн орон сууцны гадна тоглоомын талбай байгуулах 27.0 сая төгрөгийн ажил. 2016 он:
- Замын-Үүд Хилийн замын харуулын /3-ын хаалт/ 99.5 сая төгрөгийн тохижилт 2014 он:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2013-2017 онд хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдээс 436.8 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

- 2015 онд хийгдсэн 12.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй элсний волейбол, сагсны талбай-Замын Үд сум
- 2016 онд хийгдсэн 33.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй багуудын хаяг-Замын Үүд сум
- 2017 онд хийгдсэн 24.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Өндөр довын усан сангийн худаг-Сайншанд сум 4 дүгээр баг
- 2016 онд хийгдсэн 51.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Зорчигч тээврийн автобусны зогсоол-Сайншанд сум
- 2017 онд хийгдсэн 314.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сайншанд суманд суурилуулсан камер-Аймгийн Цагдаагийн газар

Төсвийн тухай хуулийн 6.3.2-т “Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалтыг нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ” гэсэн заалтын дагуу ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдсэн 349.5 сая төгрөгийн, хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн 412.2 сая төгрөгийн нийт 761.7 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгуулахаар 5 албан шаардлага бичив.

Хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг ашиглагч байгууллага бус өөр байгууллага хариуцах, нэг байршилд байгаа хөрөнгийг хоёр өөр байгууллага тус тусдаа бүртгэсэн, нэг хөрөнгө 2 өөр байгууллагад зэрэг бүртгэсэн зэрэг дараах зөрчлүүд байна. Тухайлбал:

- Тасалбар хураах цэгийн 113.5 сая төгрөгийн өртөгтэй барилгын ашиглагч байгууллага Сайншанд сумын ЗДТГазар боловч гаднах тохижилт, урсгал засвар үйлчилгээг Сайншанд Хот тохижилтын газар хариуцан ажилладаг

бөгөөд тайлант онд постын өргөдөг хаалт худалдан авах, гаднах засварын ажилд 1.1 сая төгрөгийг байгууллагын төсвөөс зарцуулжээ.

- Сайншанд сумаас 15 км-ийн зайд байрлалтай Иргэдийн цэцэрлэгт хүрээлэнгийн хашаа Сайншанд Хот тохижилтын газрын дансанд, харин уг хашаан дотор байрлах 40.0 сая төгрөгийн өртөгтэй усан сангийн худаг Сайншанд сумын ЗДТГ-ын дансанд тус тус бүртгэлтэй байна.
- Өсөх бэйс ХХК-аас 2013 онд хүлээлгэн өгсөн 36.3 сая төгрөгийн өртөгтэй “Hyundai county” маркийн автобус Замын-үүд сумын Захирагчийн ажлын алба болон НААҮ ОНӨ ХХК-д тус тус бүртгэлтэй байна.

Дээрх хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандарт, журмын дагуу балансаас балансад шилжүүлэн, залруулан бүртгэх 189.8 сая төгрөгийн 3 албан шаардлага өгөв.

Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж ашиглалтад оруулсан хөрөнгийг анхан шатны баримтаар тулган шалгаж, ашиглагч байгууллагын бүртгэл тайланд тусгуулан⁹ бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Өмнөх онуудад өгөгдсөн аудитын зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын үр дүнд хийсэн нийцлийн аудитаар 2013-2016 онд нийт 9410.3 сая төгрөгийн зөрчил илрүүлж 5741.9 сая төгрөгийн албан шаардлага, 44.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоожээ. Үүнээс 1128.3 сая төгрөгийн албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2013-2017 онуудад санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитаар нийт 7,080.5 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 2,274.5 сая төгрөгийн албан шаардлага, 36.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 4,769.8 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна.

Үүнээс 12.4 сая төгрөгийн төлбөрийн акт, 2,170.6 сая төгрөгийн албан шаардлага хэрэгжиж, 103.9 сая төгрөгийн 5 албан шаардлагын хариуг нотлох баримтын хамт ирүүлээгүй байна. Үүнд:

- 2016 оны 6 дугаар сарын 02/11 дугаартай 9.9 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгуулах, залруулага хийлгэх тухай
- 2016 оны 6 дугаар сарын 02/13 дугаартай 13.6 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгуулах тухай
- 2016 оны 6 дугаар сарын 02/14 дугаартай 36.0 төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг бүрэн гүйцэтгэж дуусгах тухай
- 2017 оны 6 дугаар сарын 07/26 ҮАГ-ГАГ/2017/02/ГА-ДГА дугаартай 12.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг ашиглалтанд хүлээлгэн өгч, бүртгэлд тусгах тухай

⁹. Сангийн сайдын 2016 оны 415 тушаалын 6.1-д ...хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил нь төрийн эсвэл орон нутгийн өмчид заавал бүртгэгдэх бөгөөдашиглалтад авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр санхүүгийн тайландаа тусгана.

- 2017 оны 6 дугаар сарын 10/29 ҮАГ-ГАГ/2017/02-ГА-ДГА дугаартай 32.4 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусах тухай

Хөрөнгө оруулалтын үр дүнг хангахад чиглүүлсэн, алдаа дутагдал давтан гарахаас сэргийлэх, арилгах чиглэлээр өгөгдсөн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар идэвх санаачилгагүй ажиллаж байгаа нь хөрөнгө оруулалтын үр нөлөөг бууруулж байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Захиалагч, гүйцэтгэгчийн ажлын хариуцлагагүй байдлаас орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2013-2017 онд хэрэгжүүлсэн 244.5 сая төгрөгийн төсөл арга хэмжээ өнөөг хүртэл дуусаагүй байна.

Орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэл чанаргүй, дутуу гүйцэтгэсэн байхад хүлээн авч “Хөрөнгийг ашиглалтад оруулах комиссын акт” үйлдсэн албан тушаалтнуудад хариуцлага тооцоогүй байна.

Шат шатны ИТХ болон Засаг дарга нар хуульд заасан орон нутгийн өмчийн талаарх бүрэн эрхээ хангалтгүй хэрэгжүүлж ажилласан байна.

Ашиглагч байгууллага хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, бүртгэл тайлагнал, хөрөнгө оруулалтын үр дүнг сайжруулах талаар ажил зохион байгуулаагүйгээс хөрөнгө ашиглалтгүй байсаар байна.

Хөрөнгө оруулалтын үр дүнг хангахад чиглүүлсэн, алдаа дутагдал давтан гарахаас сэргийлэх, арилгах чиглэлээр өгөгдсөн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар төрийн захиргааны байгууллагууд идэвх санаачилгагүй ажилласан ба хөрөнгө оруулалтын үр ашиг, үр дүнд тавих хяналт орхигдсон байна.

Аудитаар нийт 2442.4 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж, 1525.0 тэрбум төгрөгийн 20 албан шаардлага бичлээ.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аймгийн ИТХ-д:

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан орон нутгийн өмчийн талаарх бүрэн эрхийн дагуу хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт шалгалтын ажил зохион байгуулах

Аймгийн Засаг даргад:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилт, ашиглалтад хүлээн авах комиссын үйл ажиллагаа, эзэмшигч байгууллагуудын хөрөнгийн ашиглалтын байдал, бүртгэл тайлагналын асуудлуудаар тодорхой ажил зохион байгуулж хөрөнгө оруулалтын үр ашиг, үр дүнг сайжруулах
- Барилга байгууламжийг ашиглалтад оруулах үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хууль дүрмийн хүрээнд зохион байгуулаагүй, хариуцлагагүй ажилласан албан тушаалтанд хариуцлага тооцох арга хэмжээг авч хэрэгжүүлэх

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ДОРНОГОВЬ АЙМАГ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
Утас: (705) 2-30-09, факс: (705) 2-31-40,
E-mail: dornogobi.ith@gmail.com

2018.10.09 № 335
танай 2018.10.02-ны № 1-6/560 -т


ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.АРИУНАА
ТАНАА

2013-2017 онуудад орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

Аудитаар ирүүлсэн асуудалтай санал нийлж байгаа бөгөөд цаашид аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно.

ДАРГА

С.ТҮМЭНБАЯР



000566



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,

Утас/факс: (705) 2-25-33

E-mail: dornogobi_mgl@yahoo.com

2018.10.09 № 1/1774

танай _____ -ны № _____ -т

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Танай байгууллагын 2018 оны төлөвлөгөөний дагуу 2013-2017 оны аймгийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Сумдын ЗДТГ, төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд шалган туслах шалгалтын бүрэлдэхүүн бүх суманд ажиллах гэж байгаатай холбогдуулан сумдын удирдлагуудад үүрэг, чиглэлийг өгч ажиллаж байна.


Шалгалттай холбоотой санал байхгүй болно.



Г.ЭНХТҮВШИН

02 1914

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛАХ ТУХАЙ


**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**


2018 оны 10 сарын 12 өдөр Дугаар А/22 Дорноговь аймаг, Сайншанд сум

**Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 15 дугаар зүйлийн 15.1.12, 15.2.2, 19.3.3, Монгол улсын Ерөнхий аудиторын 2003 оны 53 дугаар тушаалаар баталсан "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам", 2017 оны А/188 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4, 2016 оны А/92 тоот тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн нийлүүлэх төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн "Өмнөх онуудад орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлан, албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Лүндэгмаа/-д үүрэг болгосугай.
3. Аудитын тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

9825957

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН:

АУДИТОР

П.ЭНХБАЯР

АУДИТОР

Б.ТУНГАЛАГТУЯА

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕРИЙН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.ЛҮНДЭГМАА

АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОНД
ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛБЕ.